

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хорооны 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/103/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Лхагвацэнд Утас: 261885 Цахим хаяг: khagvatsendb@audit.gov.mn Аудитор: П.Цогзолмаа Утас: 261740 Цахим хаяг: tsogzolmaap@audit.gov.mn Нийслэл-Аудит ХХК-ийн захирал: Т.Сугарсүрэн Утас: 70110095 Цахим хаяг: info@niislelaudit.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25 № 07/777

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хорооны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон зорилтот түвшний гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хорооны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон бидний тогтоосон 17.4 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Тайлант онд 25 ажилтанд 162 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж, 23.8 сая төгрөгийн 13 дахь сарын цалин, 135.3 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгосон.
- Томилолтонд зарцуулсан 11.2 сая төгрөгийн шатахууны зардлыг анхан шатны баримтгүй хаасан,
- Тайлант хугацааны 16.2 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээний худалдан авалт нь төлбөрийн И баримтгүй зэрэг зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.3 заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Z:\Yawsan_Bichig\2024\0315 SNAG-63.Docx

0001051653

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол улсын Засгийн газрын 211 дүгээр тогтоолоор Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол улсын Засгийн газрын 211 дүгээр тогтоол, Барилга хот байгуулалтын сайдын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 242 дугаар тушаалаар батлагдсан төрөөс хариуцах цэвэр, бохир усны хэрэглээг зохицуулах журмыг хэрэгжүүлэхдээ Хороо нь Ус сувгийн удирдах газар, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг эрхлэж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч хувийн хэвшлийн 78 аж ахуйн нэгжийн хоорондын тооцоогоор төрөөс хариуцах цэвэр бохир усны төлбөрийг 7,282.9 сая төгрөгөөр давхардуулан олгосон байна. Энэхүү давхардуулан олгосон төлбөрийг аж ахуйн нэгж байгууллагуудаас эргүүлэн татан төвлөрүүлэх үүргийг зохицуулах хорооны удирдлагад хүргүүлсэн бөгөөд одоогоор 2,095.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хорооны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, компанийн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант оны нийт орлогыг 1,458.0 сая төгрөг, нийт зардлыг 1,458.0 сая төгрөг байхаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 1,675.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,654.3 сая төгрөгийн зардал гарган, 21.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд хөрөнгө зарцуулаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хороо нь 2023 онд үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлангаар 5 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн 96.7 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	555,648,229.89	536,417,113.71
1.1.2	Дансны авлага	-	675,155,905.69
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	96,800.02
1.1.4	Бусад авлага	4,681,903,115.19	2,187,083,011.29
1.1.6	Бараа материал	25,823,020.22	21,505,383.22
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	5,263,374,365.30	3,420,258,213.93
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	785,894,511.62	217,958,864.55
1.2.2	Биет бус хөрөнгө	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	785,894,511.62	217,958,864.55
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,049,268,876.92	3,638,217,078.48
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	4,517,406,412.18	2,095,869,839.14
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	-	7,754,238.48
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,517,406,412.18	2,103,624,077.62
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	4,517,406,412.18	2,103,624,077.62
2.3	Эздийн өмч	20,000.00	20,000.00
2.3.1	Өмч:-төрийн	20,000.00	20,000.00
2.3.2	хувийн	-	-
2.3.3	хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	8,029,219.75
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	1,531,842,464.74	1,526,543,781.11
2.3.10	Тусга зориулалтын нөөцийн сан	-	-
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,531,862,464.74	1,534,593,000.86
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	6,049,268,876.92	3,638,217,078.48

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	26,909,370,421.24	1,565,029,088.34
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг(алдагдал)	26,909,370,421.24	1,565,029,088.34
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
8	Бусад орлого	820,222,400.00	110,459,750.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,405,008,532.96	1,654,295,256.97
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	26,163,220,950.71	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	161,363,337.57	21,193,581.37
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	161,363,337.57	21,193,581.37
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	161,363,337.57	21,193,581.37
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	161,363,337.57	21,193,581.37
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйлажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	27,729,053,209.24	1,645,295,620.10
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,341,105,801.00	1,456,612,170.10
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	25,567,725,008.24	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	820,222,400.00	188,683,450.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	27,463,368,719.56	1,664,526,736.28
1.2.1	Ажиллагчдад төлсөн	814,669,148.00	805,830,019.72
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	213,712,258.67	111,700,016.17
1.2.3	Бараа материал худалданавахад төлсөн	16,006,993.00	22,621,018.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	5,645,676.46	7,649,053.44
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	47,452,405.00	10,239,778.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	81,205,606.89	81,162,556.52
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	3,137,720.00	2,079,180.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	26,281,538,911.54	623,245,114.43
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	265,684,489.68	(19,231,116.18)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	265,684,489.68	(19,231,116.18)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	289,963,740.20	555,648,229.88
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	555,648,229.88	536,417,113.71

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,000.00		1,370,479,127.17	1,370,499,127.17
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
Залруулсан үлдэгдэл	20,000.00		1,370,479,127.17	1,370,499,127.17
Өмчит гарсан өөрчлөлт			-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			161,363,337.57	161,363,337.57
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			-	-
Зарласан ногдол ашиг				-
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,000.00	-	1,531,842,464.74	1,531,862,464.74
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(26,492,265.00)	(26,492,265.00)
Залруулсан үлдэгдэл	20,000.00	-	1,505,350,199.74	1,505,370,199.74
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			21,193,581.37	21,193,581.37
Зарласан ногдол ашиг			-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		8,029,219.75		8,029,219.75
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,000.00	8,029,219.75	1,526,543,781.11	1,534,593,000.86

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
A	Борлуулалтын орлого		27,729,592,821.2	1,458,056,440.0	1,675,488,838.3	(217,432,398.3)	115
5	Нийт орлого	төгрөг	27,729,592,821.2	1,458,056,440.0	1,675,488,838.3	(217,432,398.3)	115
6	Үүнээс: Цэвэр орлого	төгрөг	26,909,370,421.2	1,458,056,440.0	1,565,029,088.3	(106,972,648.3)	107
7	Бусад орлого	төгрөг	820,222,400.0	-	110,459,750.0	(110,459,750.0)	-
B	Нийт зардал	төгрөг	27,568,229,483.7	1,458,056,440.0	1,654,295,257.0	(196,238,817.0)	113
8	Ерөнхий ба удирдлагын зардал	төгрөг	1,405,008,533.0	1,290,090,910.3	1,251,226,698.1	38,864,212.3	97
9	Ажилчдын цалингийн зардал	төгрөг	866,201,606.7	865,364,000.0	799,727,119.7	65,636,880.3	92
10	Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	төгрөг	129,692,985.5	116,824,140.0	109,151,616.1	7,672,523.9	93
11	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	төгрөг	88,828,446.9	74,717,690.3	74,717,690.3	0.0	100
12	Томилолтын зардал	төгрөг	174,619,247.0	114,365,800.0	120,527,496.0	(6,161,696.0)	105
13	Бичиг хэргийн зардал	төгрөг	10,537,743.0	9,508,800.0	13,632,637.0	(4,123,837.0)	143
14	Шуудан холбооны зардал	төгрөг	14,351,202.5	14,972,900.0	7,400,085.4	7,572,814.6	49
15	Даатгалын зардал	төгрөг	3,137,720.0	2,079,180.0	2,079,180.0	-	100
16	Ашиглалтын зардал	төгрөг	6,645,676.5	7,200,000.0	10,030,000.0	(2,830,000.0)	139
17	Түрээсийн зардал	төгрөг	72,744,000.0	72,744,000.0	99,967,053.4	(27,223,053.4)	137
18	Шатахууны зардал	төгрөг	38,249,905.0	12,314,400.0	13,993,820.0	(1,679,420.0)	114
20	Бусад зардал	төгрөг	26,163,220,950.7	167,965,529.7	403,068,558.9	(235,103,029.2)	240
Г	Татвар төлөхийн өмнөх ашиг	төгрөг	161,363,337.6	(0.0)	21,193,581.4	(21,193,581.4)	-
21	Цэвэр ашиг	төгрөг	161,363,337.6	-	21,193,581.4	(21,193,581.4)	-
22	Ажиллагсдын тоо	тоо	22	26	25	1	96

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 39.8 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 39.8 сая төгрөгийн алдааг залруулуулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Элэгдлээрээ өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг дахин үнэлж бүртгэлд тусгахдаа үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэсэн	1	8,026.2			1	8,026.2	1	8,026.2				
НБББББ-ийг бараа үйлчилгээний бусад зардлаар бүртгэсэн.	1	15,000.0			1	15,000.0	1	15,000.0				
Үл хөдлөх хөрөнгийн эрх нь шилжин ирээгүй байгаатай холбоотойгоор аудитын залруулга хийгдсэн барилгын хуримтлагдсан элэгдлийг данснаас хасахдаа тайлант үеийн зардлаар бүртгэсэн	1	16,773.4			1	16,773.4	1	16,773.4				
Дүн	3	39,799.6			3	39,799.6	3	39,799.6				

Аудитаар нийт 163.4 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 0.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 135.3 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 27.2 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд үйлчилгээний авто машины шатахуун зарцуулалт нь батлагдсан нормоос 345.1 л буюу 0.8 сая төгрөгөөр илүү байгаа	1	824.7	1	824.7								
Тайлант онд 25 ажилтанд 162 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж, 23.8 сая төгрөгийн 13 дахь сарын цалин, 135.3 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгосон.	1	135,334.0			1	135,334.0						
Тайлант хугацааны 16.2 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээний худалдан авалт нь төлбөрийн И баримтгүй.	1	16,095.8					1	16,095.8				
Томилолтонд зарцуулсан 11.2 сая төгрөгийн шатахууны зардлыг анхан шатны баримтгүй хаасан.	1	11,135.2					1	11,135.2				
Дүн	4	163,389.7	1	824.7	1	135,334.0	2	27,231.0				

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1,293.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1,293.5 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд орлого, зарлагын 1,293.5 сая төгрөгийн 58 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байна.	1	1,293,483.3			1	1,293,483.3		
Дүн	1	1,293,483.3			1	1,293,483.3		